

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ХЭА-2022/72/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чингис хот 2022 он	Тэргүүлэх аудитор:	Ч.Эрдэнэбаатар
	Утас:	70562112
	Аудитын менежер:	Д.Оюунтуяа
	Утас:	99775390
	Өндөрхаан итгал аудит ХХК-ийн:	
	Аудитор:	Б.Маналсүрэн
	Утас:	99059424

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХЭА-2022/72/НА-СТА-ТШЗ

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	4
3.1 Ерөнхий зүйл	4
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	4
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	4
3.4 Материаллаг байдал	5
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	5
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	5
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	7
3.8 Аудитын гол асуудал	7
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	7
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	7
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	8
4. Аудитын илрүүлэлт	8
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	9

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

᠒᠐᠒᠒.03.23 № 305

танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

E:/DOTOOD AJIL/БХ 2022/явсан бичиг/A4 20220323 305

023 137

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	69,116,183.43	76,304,157.43
35	БАРАА МАТЕРИАЛ	69,116,183.43	76,304,157.43
354	Хангамжийн материал	69,116,183.43	76,304,157.43
35410	Бичиг хэргийн материал	5,205,726.43	5,205,726.43
35420	Аж ахуйн материал	49,509,657.00	50,305,961.00
35430	Сэлбэг хэрэгсэл	85,000.00	85,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,552,000.00	-
35450	Барилгын засварын материал	11,677,000.00	18,147,000.00
35460	Хүнсний материал	86,800.00	2,560,470.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,571,048,223.88	1,517,465,252.93
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,571,048,223.88	1,517,465,252.93
392	Биет хөрөнгө	1,555,254,223.96	1,501,727,253.05
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,478,383,053.00	1,478,383,053.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(39,072,580.80)	(68,376,278.28)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	80,545,681.00	80,545,681.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(32,036,390.03)	(44,753,868.26)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	82,607,782.92	82,607,782.92
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,110,655.17)	(28,960,450.33)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,756,000.00	3,756,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(818,666.96)	(1,474,667.00)
393	Биет бус хөрөнгө	15,793,999.92	15,737,999.88
39301	Програм хангамж	280,000.00	280,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(112,000.08)	(168,000.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	15,626,000.00	15,626,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН Ш=I+II	1,640,164,407.31	1,593,769,410.36
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,640,164,407.31	1,593,769,410.36
51	Засгийн газрын хувь оролцоо	1,640,164,407.31	1,593,769,410.36
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	71,668,484.50	71,668,484.50
512	Хуримтлагдсан үр дүн	1,510,841,843.18	1,464,446,846.23
51210	Өмнөх үеийн үр дүн	1,510,841,843.18	1,510,841,843.18
51220	Тайланг үеийн үр дүн	-	(46,394,996.95)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	57,654,079.63	57,654,079.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,640,164,407.31	1,593,769,410.36

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31

/Төгсгөрөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	466,693,728.00	454,380,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,379,528.00	500,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,379,528.00	500,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,379,528.00	500,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,379,528.00	500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	461,314,200.00	453,880,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	425,421,000.00	409,628,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	425,421,000.00	409,628,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	461,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	195,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	266,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	35,893,200.00	43,790,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,893,200.00	43,790,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	451,171,838.85	500,775,496.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	451,171,838.85	500,775,496.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	438,904,134.86	489,391,338.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	263,544,265.00	286,941,023.00
210101	Үндсэн цалин	189,477,792.00	214,270,326.00
210102	Нэмэгдэл	49,727,702.00	44,645,287.00
210104	Урамшуулал	16,029,438.00	17,390,670.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,309,333.00	10,634,740.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,454,357.01	37,552,118.01
210201	Тэтгэврийн даатгал	22,581,878.32	26,041,568.11
210202	Тэтгэмжийн даатгал	2,893,062.25	2,894,610.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,128,455.99	2,312,326.77
210204	Ажил үйлдлийн даатгал	530,773.26	571,040.67
210205	Эрүүл мэндийн даатгал	5,320,187.19	5,732,572.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,182,000.00	43,342,490.00
210301	Гэрэл, цахилгаан	4,003,974.00	2,494,650.00
210302	Түлш, халаалт	36,178,026.00	40,847,840.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,362,648.83	28,476,196.00
210401	Бичиг хэрэг	146,500.00	325,000.00
210402	Тээвэр, шатахуун	499,834.00	585,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,008,000.00	60,000.00
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	225,650.00	143,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,760,600.00	5,624,800.00
210408	Бараа материал акталсны зардал	16,722,064.83	21,737,196.00
2105	Нормативт зардал	22,180,420.00	19,909,541.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	109,750.00	148,000.00
210502	Хоол, хүнс	22,070,670.00	19,595,541.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдтэл	-	166,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	483,000.00	515,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-
210602	Тавилга	-	-
210604	Урсгал засвар	483,000.00	515,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	138,000.00
210702	Дотоод албан томилолт	-	138,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,209,000.00	15,540,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,885,000.00	15,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	540,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,488,444.02	56,976,970.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	110,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,088,000.00	3,284,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,400,444.02	53,582,970.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,267,703.99	11,384,157.99
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	295,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	295,000.00
213405	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		
		202,200.00	2,519,210.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	202,200.00	2,515,210.00
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг		4,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,065,503.99	8,569,947.99
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,065,503.99	8,569,947.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	15,521,889.15	(46,394,996.95)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,584,782.27	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,584,782.27	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,584,782.27)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	13,937,106.88	(46,394,996.95)

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛГИЙН ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь өрөлцөөний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	71,668,484.50	57,654,079.63	1,496,904,736.30	1,626,227,300.43
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	71,668,484.50	57,654,079.63	1,496,904,736.30	1,626,227,300.43
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	13,937,106.88	13,937,106.88
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	71,668,484.50	57,654,079.63	1,510,841,843.18	1,640,164,407.31
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	71,668,484.50	57,654,079.63	1,510,841,843.18	1,640,164,407.31
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	71,668,484.50	57,654,079.63	1,510,841,843.18	1,640,164,407.31
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валетын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(46,394,996.95)	(46,394,996.95)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	71,668,484.50	57,654,079.63	1,464,446,846.23	1,593,769,410.36

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2021 оны 12-р сарын 31

/Төгсгөрсөп/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	461,314,200.00	453,880,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	461,314,200.00	453,880,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	425,421,000.00	409,628,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	425,421,000.00	409,628,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	461,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	195,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	266,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	35,893,200.00	43,790,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,893,200.00	43,790,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	396,639,800.00	453,880,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	396,639,800.00	453,880,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	384,372,096.01	442,496,342.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	263,537,266.00	286,941,023.00
210101	Үндсэн цалин	189,465,793.00	214,270,326.00
210102	Нэмэгдэл	49,727,702.00	44,645,287.00
210104	Урамшуулал	16,029,438.00	17,390,670.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,314,333.00	10,634,740.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,454,356.01	37,552,118.01
210201	Тэтгэврийн даатгал	22,581,878.32	26,041,568.11
210202	Тэтгэмжийн даатгал	2,893,062.25	2,894,610.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,128,455.99	2,312,326.77
210204	Ажилгүйдлийн даатгал	530,773.26	571,040.67
210205	Эрүүл мэндийн даатгал	5,320,186.19	5,732,572.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,208,000.00	40,790,490.00
210301	Гэрэл, цахилгаан	4,003,974.00	2,494,650.00
210302	Түлш, халаалт	31,204,026.00	38,295,840.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,737,584.00	12,955,500.00
210401	Бичиг хэрэг	902,500.00	1,305,000.00
210402	Тээвэр, шатахуун	499,834.00	497,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	783,000.00	140,000.00
210404	Ном, хэвлэл	60,000.00	63,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	225,650.00	143,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,266,600.00	10,806,300.00
210408	Бараа материал акталсны зардал	-	-
2105	Нормативт зардал	18,964,890.00	22,677,211.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	58,000.00	58,000.00
210502	Хоол, хүнс	18,351,890.00	22,069,211.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	555,000.00	550,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,089,000.00	485,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	650,000.00	-
210602	Тавилга	956,000.00	-
210604	Урсгал засвар	483,000.00	485,000.00
2107	Томилголт, зочны зардал	-	105,400.00
210702	Дотоод албан томилголт	-	105,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,209,000.00	25,040,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,885,000.00	24,500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	540,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,172,000.00	15,949,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	110,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,172,000.00	15,839,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,267,703.99	11,384,157.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	295,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	295,000.00
213405	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	202,200.00	2,519,210.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	202,200.00	2,515,210.00
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг		4,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,065,503.99	8,569,947.99
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,065,503.99	8,569,947.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	64,674,400.00	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	64,674,400.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	64,674,400.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	64,674,400.00	-
223001	Бусад хөрөнгө	64,674,400.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(64,674,400.00)	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэг
АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭГТЭЛИЙН ТАЙЛАН

ТГ

2021 оны 12-р сарын 31

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	453,418,900.00	442,333,742.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	453,418,900.00	442,333,742.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	453,118,900.00	442,038,742.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	288,802,400.00	286,941,023.00
210101	Үндсэн цалин	203,469,000.00	214,270,326.00
210102	Нэмэгдэл	54,518,400.00	44,645,287.00
210104	Урамшуулал	18,523,200.00	17,390,670.00
210105	Гэрээг ажлын хөлс	12,291,800.00	10,634,740.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,047,100.00	37,552,118.01
210201	Тэтгэврийн даатгал	28,565,000.00	26,041,568.11
210202	Тэтгэмжийн даатгал	3,120,500.00	2,894,610.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,496,400.00	2,312,326.77
210204	Ажилгүйдлийн даатгал	624,100.00	571,040.67
210205	Эрүүл мэндийн даатгал	6,241,100.00	5,732,572.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,305,500.00	40,790,490.00
210301	Гэрэл, цахилгаан	5,000,000.00	2,494,650.00
210302	Түлш, халаалт	38,305,500.00	38,295,840.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,525,600.00	12,497,900.00
210401	Бичиг хэрэг	1,103,200.00	1,103,000.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	497,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,083,600.00	80,000.00
210404	Ном, хэвлэл	63,100.00	63,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутга	240,000.00	143,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,535,700.00	10,610,700.00
2105	Нормативт зардал	24,799,800.00	22,677,211.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	58,000.00	58,000.00
210502	Хоол, хүнс	24,185,200.00	22,069,211.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдтэл	556,600.00	550,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	485,200.00	485,000.00
210604	Урсгал засвар	485,200.00	485,000.00
2107	Томьлолт, зочны зардал	105,400.00	105,400.00
210702	Дотоод албан томьлолт	105,400.00	105,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураан	25,040,000.00	25,040,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	24,500,000.00	24,500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,007,900.00	15,949,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	153,000.00	110,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,854,900.00	15,839,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00	295,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	295,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	295,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	453,418,900.00	442,333,742.01
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	409,628,200.00	401,058,252.01
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	409,628,200.00	401,058,252.01
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	43,790,700.00	41,275,490.00
132001	Орон нутгийн төсвөөс	43,790,700.00	41,275,490.00

АУДИТ ХИЙГДСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

2021 оны 12-р сарын 31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	461,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	461,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	457,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	457,600.00
210401	Бичиг хэрэг	-	202,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	195,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		4,000.00
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг		4,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	461,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	461,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	195,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	266,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Өндөрхаан итгэл аудит ХХК-ийн аудитор О.Энхтунгалаг, аудиторын туслах М.Мөнхзаяа нар гүйцэтгэж, хяналтыг компанийн захирал, аудитор Б.Маналсүрэн, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Өндөрхаан итгэл аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дэлгэрхаан сумын Цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг Сургуулийн өмнөх насны боловсролын тухай хуулиар дараах байдлаар тодорхойлжээ.Үүнд:"Бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино" гэж заасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлаа сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 451.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,511.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.609.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 46,395.0 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	69,116.2	76,304.2	7,188.0
Үндсэн хөрөнгө	1,571,048.2	1,517,465.2	(53,583.0)
Нийт хөрөнгө	1,640,164.4	1,593,769.4	(46,395.0)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	71,668.5	71,668.5	-
Хуримтлагдсан үр дүн	1,510,841.8	1,464,446.8	(46,395.0)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	57,654.1	57,654.1	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,640,164.4	1,593,769.4	(46,395.0)

Бараа материалын дансны үлдэгдэл нь 76,304.2 мянган төгрөг болж 7,188.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 61,101.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 54,413.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,517,465.2 мянган төгрөг болж 53,583.0 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардал нөлөөлжээ.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 1,464,446.8 мянган төгрөг болж, 46,395.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үр дүнгийн бууралт нөлөөлсөн байна.

Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 12,313.2 мянган төгрөгөөр буюу 2.6 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь улсын төсвөөс олгосон санхүүжилт 15,792.8 мянган төгрөгөөр буурч, орон нутгийн төсвийн санхүүжилт 7,897.5 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 49,603.6 мянган төгрөгөөр буюу 11 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлуудыг авч үзвэл нэмэгдэл цалингийн зардал 26,396.7 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 4,097.7 мянган төгрөгөөр, байр ашиглалтын тогтмол зардал 3,160.5 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 8,113.6 мянган төгрөгөөр өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 549,864.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 96,445.4 мянган төгрөгөөр бууруулан нийт зарлагыг 453,418.9 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд: цалин нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 10,709.1 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 20,477.0 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 59,324.9 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 453,418.9 мянган төгрөгөөр баталсанаас 409,628.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 43,790.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 409,628.2 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 43,790.7 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус авч, урсгал үйл ажиллагаанд 442,333.7 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 8,570.0 мянган төгрөг, орон нутгийн төсөвт 2,515.2 төгрөгийг тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 442,333.7 мянган төгрөг буюу 97.6 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 1,861.4 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2,515.0 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 2,115.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 461.6 мянган төгрөгийн орлого орж, 457.6 мянган төгрөгийг зарцуулж, 4.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт хамааралтай асуудал илрээгүй.

3.8 Аудитын гол асуудал

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй, өмнөх онд итгэл үзүүлж, аудит хийгдээгүй болно.

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх, анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 10,026.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 3,502.4 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 6,524.4 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй.

4.2 Төлбөрийн акт

4.2.1 Нэр бүхий аж ахуйн нэгжээс 2,900.0 мянган төгрөгөөр худалдан авсан ариутгалын бодисын нэр төрөл нь тодорхойгүй орлого, зарлагын гүйлгээг данс бүртгэлд тусгасан.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоох

4.2.2 Тайлант онд 1 хүүхдэд ногдох хоолны зардлыг нормативаас 602.2 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоох

4.3 Албан шаардлага

Байхгүй

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал.

Илрүүлэлт:

4.4.1.Шалгагдагч байгууллагын төлбөрийн баримтын цахим системд бүртгэгдсэн дүн нягтлан бодох бүртгэлд бүртгэгдсэн дүнгээс 6.524.4 мянган төгрөгөөр дутуу байгаа нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6, Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтууд, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.1. Өгсөн зөвлөмж: Цаашид цахим төлбөрийн баримтгүй худалдан авалт хийхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Дэлгэрхаан сумын цэцэрлэг	1	10,026.8			2	3,502.4			1	6,524.4
	Дүн	1	10,026.8			2	3,502.4			1	6,524.4



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 36/23910610

Чингис хот

ХЭА-2022/72/НА-ЕТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ.

Нэр бүхий аж ахуйн нэгжээс худалдан авсан 2,900.0 мянган төгрөгийн ариутгалын бодис нь ямар бодис нь тодорхойгүй орлого, зарлагын гүйлгээг данс бүртгэлд тусгасан, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах," 20 дугаар зүйлийн 20.2.4" нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах," хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн", гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Тодорхойгүй зарлагдсан 2,900.0 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Д.Долгорсүрэн, нягтлан бодогч Д.Энхсаруул нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ӨНДӨРХААН ИТГЭЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН МЕНЕЖЕР

Б.МАНАЛСҮРЭН

Д.ОЮУНТУЯА

237144297
СНОА0046 9074082



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 37/23910610

Чингис хот

ХДА-2022/72/НА ЕТА ТЦС

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ.

Тайлант онд 1 хүүхдэд ногдох хоолны зардлыг нормативаас 602.2 мянган төгрөгөөр хэтрүүлсэн зарцуулсан.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Хоолны зардлын норматив тогтоох тухай" 450 тоот тогтоолоор батлагдсан "Цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 2,475 (хоёр мянга дөрвөн зуун далан таван) төгрөгөөр тогтоосныг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.4.2.3.6. "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан;" гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Норматив хэтрүүлж зарцуулсан 602.2 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дэлгэрхаан сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Д.Долгорсүрэн, нягтлан бодогч Д.Энхсаруул нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ӨНДӨРХААН ИТГЭЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Б.МАНАЛСҮРЭН

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА

